



МУГЕГ-ын даргын 2003 оны  
245 дугаар тушаалын хавсралт

## ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гадаад худалдааг дэмжих, гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, хүнд суртлыг багасгах, зорилгоор гаалийн байгууллагын итгэл хүлээсэн аж ахуйн нэгж /цаашид “аж ахуйн нэгж гэх”/-ийг шалгаруулж экспорт, импортын гаалийн бүрдүүлэлтийн шуурхай байдлыг хангах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Архи, тамхи, бүх төрлийн дарс, пиво импортлоход 4.1-т заасан хөнгөлөлттэй үйлчилгээг үзүүлэхгүй.

1.3. Энэ журмын “Хоёрт” заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгжүүдийг Гаалийн хяналт шалгалтын хэлтэс, Татвар орлогын хэлтэс хамтран шалгаруулж, дүгнэлт гаргах ба ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар энэхүү журмын дагуу гаалийн байгууллагын итгэл хүлээсэн аж ахуйн нэгжид эрх олгох, олгосон эрхийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

Хоёр. Шалгаруулах үзүүлэлт

- 2.1. Тухайн аж ахуйн нэгж нь гаалийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн зөрчил гаргаагүй байх;
- 2.2. Гаалийн байгууллагад татварын өр, авлагын тооцоогүй байх;
- 2.3. Сүүлийн жилд улсын төсөвт болон гаалийн байгууллагад оруулсан татвар, хураамжийн дүн буураагүй байх;
- 2.4. Шаардлагатай гэж үзсэн холбогдох эрх бүхий байгууллагын тодорхойлолт.

Гурав. Аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

- 3.1. Энэхүү журмын 2-т заасан үзүүлэлтийг бүрэн хангасан аж ахуйн нэгж нь 4.1-т хөнгөлөлт үйлчилгээг эдэлнэ.
- 3.2. Аж ахуйн нэгж нь гаалийн урьдчилсан бүрдүүлэлтийг хийлгэж болно.
- 3.3. Энэ журмаар олгогдсон эрхээ дутуу эдэлж байна гэж үзвэл гомдлоо ГЕГ-т тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.4. Аж ахуйн нэгж нь бүрдүүлэлтийн талаарх шаардагатай бүх бичиг баримтыг гаалийн газар, хороодод шаардсан хугацаанд үнэн зөв бүрдүүлж өгч байх;
- 3.5. Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн гаргана.
- 3.6. Аж ахуйн нэгж нь гаалийн хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслээ гаалийн байгууллагад сүлжээгээр болон гаалийн зуучлагч байгууллагаар төлөөлүүлэн мэдээлж болно.

Дөрөв. Гаалийн байгууллагын эрх, үүрэг

- 4.1. Аж ахуйн нэгжийн гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа тээврийн хэрэгсэлд холбогдох бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт болон гаалийн урьдчилсан бүрдүүлэлтийг зохих журмын дагуу хийж, гаалийн шалгалт хийхгүйгээр тухайн аж ахуйн нэгжид олгож болно.

4.2. Шаардлагатай тохиолдолд бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн шалгалтыг хийнэ.

4.3. Аж ахуйн нэгжид бүрдүүлэлтийн дараах гаалийн шалгалт хийнэ.

4.4. Гаалийн байгууллага тухайн аж ахуйн нэгжийг шалгаруулалтанд оруулахаас татгалзах эрхтэй.

4.5. Аж ахуйн нэгжийн хөрөнгө, үйлдвэрлэл, худалдааны нууцыг хадгалах.

#### Тав. Хариуцлага

5.1. Аж ахуйн нэгж нь гаалийн хууль, тогтоомж зөрчсөн нь илэрсэн бол аж ахуйн нэгжид олгосон итгэлийн гэрчилгээг хүчингүй болгож холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

5.2. Гаалийн болон холбогдох хуль тогтоомжийг зөрчиж итгэлийн гэрчилгээг хураалгасан аж ахуйн нэгж нь 3 жилийн хугацаанд дахин шалгаруулалтанд орох эрхгүй болно.

#### Зургаа. Бусад зүйл

6.1. Харьяа гаалийн газар, хороод нь энэ журмын 2-т заасан үзүүлэлтүүдийг хангасан гэж үзэж байгаа аж ахуйн нэгжийг шалгаруулах саналаа гаргаж ГЕГ-т өгнө.

6.2. ГЕГ шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагад итгэлийн гэрчилгээ олгосон тухай албан ёсоор мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

6.3. Энэхүү зохицуулагдаахгүй бусад асуудлыг Монгол Улсын Гаалийн тухай хууль, Гаалийн тарифын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрхийн актуудын дагуу шийдвэрлэнэ.

---o0o---